

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
САЙД



МОНГОЛЫН
БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ




МОНГОЛЫН
БАРИЛГАЧДЫН
ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛҮҮДИЙН
ХОЛБООНЫ ДАРГА



БАРИЛГЫН САЛБАРЫН 2017-2018 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамтын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжинд нийцэж байгаа тул

2017 оны 5 дугаар сарын 2 өдөр бүртгэв.



УЛААНБААТАР ХОТ

2017 оны 4 дүгээр сарын 28

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД  Г. МӨНХБАЯР

БАТЛАВ:



**БАРИЛГЫН САЛБАРЫН 2017-2018 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2017.05.11

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан
Барилгын салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар			
1	"Барилга, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн"-өөр салбарт тулгамдаж байгаа асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хамтарч хэрэгжүүлж ажиллана.	2017.IV сар	ББМҮБХЗГ Д.Занабазар НААБХЗГ О.Лхагвацэдэн
2	"Төрөөс барилгын салбарт баримтлах бодлогын баримт бичиг"-ийг боловсруулж Засгийн газраар батлуулан хэрэгжүүлнэ.	2017.XII сар	БТГ Л.Батжаргал ББМҮБХЗГ Д.Занабазар
3	Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулна.	2017.XII сар	НААБХЗГ О.Лхагвацэдэн
4	Хот байгуулалтын тухай, Газрын тухай, Орон сууцны тухай, Хот, суурины үс хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар барилга, хот байгуулалт, газрын харилцааны салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2017-2018 он	БТГ Л.Батжаргал ХБГХБХЗГ Б.Гүнболд ИДББХЗГ Б.Соёмбоо НААБХЗГ О.Лхагвацэдэн
5	"Түрээсийн орон сууц", "Орлогод нийцсэн орон сууц" зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагааг нь дэмжих арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.	2 жилийн турш	БТГ Л.Батжаргал ТОСК Ж.Хичээнгүй
6	"Барилга паспортжуулах", "Гэр хороололын дахин төлөвлөлт", "Ухаалаг дэд бүтэц", "Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл" зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2018.XII сар	ББМҮБХЗГ Д.Занабазар ХБГХБХЗГ Б.Гүнболд ИДББХЗГ Б.Соёмбоо
7	Барилга байгууламжийн норм, нормативын сангийн зарцуулалтыг ил тод болгож, тайланг Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр ашигтай байлгах чиглэлээр хамтарч ажиллана.	2 жилийн турш	БХБЯ С.Магнайсүрэн ГЗБГЗЗГ Ц.Ганхүү
8	Улсын Их Хурлын 2014 оны 30 дугаар тогтоолын дагуу Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 18, 81 дүгээр тушаалаар баталсан "Барилгын төсөв зохиох үндсэн дүрэм", "Барилгын төсөв зохиох аргачлал"-д нэмэлт өөрчлөлт оруулах талаар холбогдох арга хэмжээг хамтран авч ажиллана.	2018.IV сар	ББМҮБХЗГ Д.Занабазар
9	Барилгын салбарт "Даатгалын тогтолцоо"-г нэвтрүүлэх чиглэлээр ХНХЯ, ЭМНДЕГ болон хувийн хэвшлийн даатгалын байгууллагуудтай уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн хамтран зохион байгуулна.	2017.XII сар	МБНХ М.Батбаатар

